

САНГИЙН
САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД

ХУУЛЬ, ЗҮЙ ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Ч.УЛААН

Ц.НЯМДОРЖ

“ТААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ
ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 3.1.11-д “үр тариа, буурцагт болон бусад таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх...”, мөн бодлогын 3.1.12-т “... уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх” зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 3.1.6-д Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай тарианы үр, улаан буудайг “стратегийн хүнс” гэж тодорхойлж, мөн хуулийн 8 дугаар зүйлд стратегийн хүнсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих талаар тусгагдсан.

Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 3.1.6-д “дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай заасан.

Монгол Улс 2019 онд 339,4 мянган га талбайд улаанбуудай тариалсан. Гэвч оны 5 дугаар сард хүйтэн сэрүүн, хүчтэй салхи шуургатай байж хаврын тариалалтын явц болон чийгийн хадгалалт, таримлын соёололтод сөргөөр нөлөөлсөн, 6 дугаар сард хуурай, халуун олон хоног үргэлжилсэн нарны хэт халалт явагдаж буудайн өсөлт хөгжилт, бутлалтыг бууруулсан зэрэг байгаль цаг уурын давагдашгүй нөхцөл үүссэн шалтгааны улмаас улсын хэмжээнд нийт 26.9 мянган га талбайн ургацыг хураах боломжгүй болсон.

Монгол Улсын хүн амын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд нийт 302.0 мянган тн улаанбуудай шаардлагатай бөгөөд 2019 онд улсын хэмжээгээр 407.6 мянган тн буудай хураан авч, гурил үйлдвэрлэлд 240.2 мянган тн буудай нийлүүлсэн байна. Харин дотоодын спиртийн үйлдвэрлэлд 10.0, малын тэжээлийн үйлдвэрлэлд 35.0, үрийн нөөцөд 42.0, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нөөцөд 20.4 мянган тн улаанбуудай нийлүүлсэн дүнтэй байгаа бөгөөд хүн амын 2019 – 2020 оны хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 60.0 мянган тонн улаанбуудай дутагдах тооцоотой байна.

Улсын хэмжээнд 2020 оны хаврын тариалалтад нийт 63.0 мянган тн үр шаардлагатай. Гэвч одоогоор салбарын аж ахуйн нэгж, иргэд 42.0 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Онцгой байдлын ерөнхий газарт 6.0 мянган тонн, нийт 48.0 мянган тонн үрийн буудайн нөөц бүрдсэн байгаа тул хаврын тариалалтад 15.0 мянган тн үрийн улаанбуудай дутагдаж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл шалтгааныг харгалзан үзэж Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 01 дүгээр зөвлөмжөөр 2020 онд 15.0 мянган тн улаанбуудайн үр, 60.0 мянган тн хүнсний улаанбуудайг импортлохоор шийдвэрлэсэн.

Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид, тариаланчдыг эрх зүй, эдийн засгийн бодлого, зохицуулалтаар дэмжих, гурилын үйлдвэрүүдийг чанартай, хямд импортын түүхий эдээр хангах, зах зээлд гурилын хангамж, үнийг тогтворжуулах, үрийн шинэчлэл хийх, нөөц бүрдүүлэх, хаврын тариалалтын бэлтгэл ажлыг шуурхай хангах зорилгоор импортлох хүнсний улаанбуудай, үрийн улаанбуудайг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төсөл хоёр зүйлтэй. Төслийн 1 дүгээр зүйлд 2020 оны хаврын тариалалтад шаардагдах 15.0 (арван тав) мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурил үйлдвэрлэлд шаардагдах 60.0 (жаран) мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөх тухай, төслийн 2 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хугацааны талаар тус тус тусгасан болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн:

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна:

- Тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тариаланчид, үйлдвэрлэгчдийн эдийн засгийн чадавхийг сайжруулах, иргэдээ аюулгүй, хүнсээр хангах нөхцөл бүрдэнэ.

- Чанартай, хямд хүнсний улаанбуудай импортлох, дотоодын гурил үйлдвэрлэгчдийг түүхий эдээр тогтвортой хангах, зах зээлд гурил, гурилан бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах нөхцөл, боломж бүрдэнэ.

- Дотоодын тариаланчдыг чанартай үрээр хангах, улаанбуудайн үрийн шинэчлэл хийх, хаврын тариалалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлж улмаар намрын ургацаас үрийн нөөц бүрдүүлнэ.

- Газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулна.

Хуулийн төсөл батлагдсанаар сөрөг үр дүн гарахгүй.

Дөрөв. Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар:

Хуулийн батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

...ooOoo...

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны дугаар сарын
...-ний өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2020 оны хаврын тариалалтад шаардагдах 15.0 (арван тав) мянган тонн улаан буудай элит үр, дотоодын гурил үйлдвэрлэлд шаардагдах 60.0 (жаран) мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

Гарын үсэг